

ХЭЛНИЙ АМЬДРАХ ЧАДВАРЫН ТАЛААРХ СУДАЛГАА
/THE SURVEY ON LANGUAGE VITALITY/

Я. БАДАМСҮРЭН¹ /BADAMSURE. YA/

Key words: Minority language, language vitality, language protection and language endangerment.

Хэл судлаачид болоод аливаа улс гүрэн, төр засгийн үүрэг нь мөхөх аюул тулгарсан, цөөнхийн хэлийг хамгаалах явдал бөгөөд өнөөдөр хэлийг хамгаалан хөгжүүлэх улс төр, эдийн засаг, хүн ам зүйн гэх мэт нийгмийн шаардлага зүй ёсоор урган гарч олон улсын байгууллагын анхаарлын төвд байна.

Дэлхийд хэдэн хэл байгаа нь нарийн тодорхой биш боловч 2007 онд Аляскийн Фэйрбанксийн их сургуулийн профессор Майкл Краус 6000 орчим амьд хэл байна гэж үзээдмөхөх аюулгүй хэл /safe/ гэдэгт ойрын 100 жилдээ тухайн үндэстнүүд нь эх хэлээрээ ярих хэлийг, мөхөх аюул тулгараад байгаа хэл /endangered/ гэдэгт ойрын 100 жилд хүүхэд залуус нь эх хэлээрээ ярихаа болих магадлалтай хэлийг, мөхсөн /moribund/ хэлэнд яг одоо хүүхэд залуус нь харилцаандаа хэрэглэхээ больсон хэлийг хэлнэ гэж тодорхойлж байсан бол хамгийн сүүлийн үеийн мэдээгээр² өнөөдөр дэлхий дээр 7105 амьд хэл байна гэж тооцоолжээ.

1995 онд НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын асуудал эрхэлсэн байгууллага /ЮНЕСКО/-аас санаачлан мөхөж байгаа хэлнүүдийн талаар баримт цуглуулж тухай тухайн хэлнүүдийн орчинд нь дүн шинжилгээ хийх зорилгоор “Мөхлийн аюулд байгаа хэлнүүдийг баримтжуулах төв”-ийг Токиод байгуулснаас хойш мөхөж байгаа хэл, тэдгээрийн газарзүйн байршлын талаар (Африк, Өмнөд Америк, Оросын Холбооны Улс гэх мэт) олон улсын чанартай хэд хэдэн уулзалт зөвлөгөөн болсны нэг нь 2003 оны 3 сард Францын нийслэл Парис хотноо болсон олон улсын шинжээчдийн хурал юм. Уг хуралд мөхөж байгаа хэлний талаар судалгаа явуулдаг НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын асуудал эрхэлсэн байгууллага /ЮНЕСКО/-ын судлаачдын бүлэг “Хэлний амьдрах чадвар ба мөхөл” гэсэн сэдвээр илтгэл тавьж хэл шинжээч, хэл

¹(МУИС. ГХСС. /ГХСТ/)

²СИЛ Интернэшнл /SIL(The Summer Institute of Language)International / олон улсын байгууллагаас эрхлэн гаргадаг Этнологи: Дэлхийн хэлнүүд /Ethnologue: Languages of the World /номын 17 дахь хэвлэл (2013)-д

төлөвлөгч, төрийн бус байгууллагын гишүүд болон мөхөж буй хэлээр харилцагчдын төлөөллөөс бүрдсэн өргөн бүрэлдэхүүнээр хэлэлцүүлсэн байна. Энэ хуралдаанаар хэлний амьдрах чадварыг тодорхойлох эцсийн баримт бичгийг боловсруулж мөхөж буй хэлний нөхцөл байдлыг сайжруулах есөн гол хүчин зүйлийг дүгнэлт болгон гаргажээ. Үүнд:

1. Тухайн хэлийг хойч үе нь өвлөж авсан эсэх
2. Тухайн хэлээр харилцагчдын тоо
3. Нийт хүн амын дунд тухайн хэлээр харилцагчдын эзлэх хувь
4. Тухайн хэлээр харилцагчдын шилжилт хөдөлгөөн
5. Тухайн хэл хүрээгээ тэлж байгаа эсэх болон хэвлэл мэдээллийн салбарт хэрэглэгдэж байгаа эсэх
6. Хэлний боловсрол болоод утга зохиолын салбарт тухайн хэлээр бэлэн хэрэглэгдэхүүн байгаа эсэх
7. Засгийн газрын болоод олон улсын хандлага, бодлого /албан ёсны статустай юу? Хэрэглээ нь ямар байна гэх мэт/
8. Тухайн хэлээр харилцагч нийгмийн бүлэглэл өөрийн эх хэлэндээ хандах хандлага
9. Тухайн хэлийг баримтжуулсан төрөл, тоо хэмжээ, түвшин зэрэг болно.

Түүнчлэн Ази номхон далайн орнуудад хэлний амьдрах чадвар болоод мөхөл (Language Vitality and Endangerment) /LVE/-ийн талаар томоохон судалгаанууд хийсний нэг нь

Австралийн судалгаа:

ЮНЕСКО-гоос гаргасан дээрх 9 хүчин зүйлд тулгуурлан “Австралийн уугуул хэл судлалын хүрээлэн” /Australian Institute of Aboriginal and Torres Islander Studies”– /AIATSIS/-гээс 2004 онд Австралийн засгийн газрын хүсэлтээр Австралийн уугуул хэлний байдалд анализ хийж “Үндэсний уугуул хэлнүүдийн судалгаа 2005” /National Indigenous Language Survey/ /NILS/ баримт бичгийг боловсруулан гаргасан байна. Энэ судалгаанд Австралийн 250 гаруй уугуул хэлнээс 145 нь хамрагдаж тэдгээрийн 110 орчим нь мөхлийн онцгой аюулд байгаа хэл /severely endangered/ болон бараг мөхсөнхэл /critically endangered/ гэсэн ангилалд багтаж ердөө 18 уугуул хэлийг л хойч үедээ өвлүүлдэг гэсэн судалгаа гарсан байна.³

“Үндэсний уугуул хэлнүүдийн судалгаа”-ны төвөөс дээрх 9 үзүүлэлт дээр 10 дахийг нь хэлний хөтөлбөрийн статус (Status of Language Programme) гэсэн нэртэйгээр нэмж үүнийгээ 6 үнэлгээгээр хэмжиж доорх хүснэгтээр харуулсан байна.

Үнэлгээ		Хэлний хөтөлбөрийн статус
Маш сайн	5	Хэлний хөтөлбөр байнга хэрэгждэг бөгөөд хүн амын 5%-иас илүүг хамардаг.
Сайн	4	Хэлний хөтөлбөр байнга хэрэгждэг бөгөөд хүн амын гуравны хоёрын 5%-иас илүүг хамардаг.

³“Үндэсний уугуул хэлнүүдийн судалгаа 2005” /National Indigenous Language Survey/ /NILS/

Дунд зэрэг	3	Хэлний хөтөлбөр байнга хэрэгждэг бөгөөд хүн амын гуравны нэгийн 5%-иас илүүг хамардаг.
Анхан шатны	2	Нийт харилцагчдын маш бага /5%-иас бага/ хүнийг хамарсан хэлний хөтөлбөр хэрэгждэг бөгөөд энэ нь маш бага, эсвэл огт үр дүнгүй байдаг.
Хангалтгүй	1	Хэлний хөтөлбөр байхгүй түүнийг хийх талаар хэсэг бусад хүмүүс зөвхөн өөр хоорондоо ярьдаг.
Байхгүй	0	Хэлний хөтөлбөр байхгүй төдийгүй түүнийг хийх сонирол ч байхгүй.

“Үндэсний уугуул хэлнүүдийн судалгаа” 2005

Хятадын судалгаа

2009 онд Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи (Chinese Academy of Social Sciences) /CASS/-ийн угсаатан болон хүн судлалын хүрээлэн (Institute of Ethnology and Anthropology)/IEA/, Хятад дахь цөөнхийн хэлний амьдрах чадварыг тодорхойлохоор дээрх 9 хүчин зүйлсийг ашиглан судалгаа явуулсны дүнд Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академиас Хятадын нийгмийн хэлшинжлэлийн онцлогт тохируулан нэмэлт 3 заалтыг санал болгосон байна.

1. Хэлний тархалт: Холимог (Үндэс угсаа ялгаатай нэг гэр бүл)
2. Хэлний дотоод өөрчлөлт: (Өөрчлөлт их гарах тусам амьдрах чадвараа алдана).
3. Хэлнүүдийн үндэстэн дамнан тархсан байдал (ихэнх судалгаанаас харахад үндэстэн дамнан тархсан хэлнүүд илүү хамгаалагдах хандлагатай байдаг. Жишээ нь: Швецари дахь Франц, Итали, Герман хэлнүүд).

Ийнхүү дээрх 9 зүйлс дээр 3-ыг нэмж эдгээр 12 ангиллыг ашиглан Хятадын Нийгмийн Шинжлэх Ухааны Академиас 100 гаруй цөөнхийг хэлийг: амьд хэл /Dynamic language/, идэвхтэй хэл/active language/, мөхлийн зарим нэг шинж тэмдэг ажиглагдсан хэл /Language of moderate vitality and showing some signs of endangerment/, мөхөх аюулд байгаа хэл /Languages of dwindling vitality/definitely endangered/, мөхлийн ирмэгт байгаа хэл /Languages of minimal vitality/severely endangered/, бараг мөхсөн эсвэл бүр мөхсөн хэл /Inactive/critically endangered or extinct languages/ гэсэн 6 ангилалд хувааж үзсэн байна.

Дээрх хоёр судалгаа нь хэлний мөхөл болоод амьдрах чадварыг тодорхойлохдоо өөрийн улс орны үндэсний онцлогт нийцүүлэн үндсэн 9 хүчин зүйл дээр нэмж үзүүлэлт гаргасан нь харагдаж байна. Бидний хувьд 2009 онд Увс аймгийн тариалан сумын хотон иргэдийн дунд явуулсан социологийн судалгаа⁴, 2010 онд Хөвсгөл аймгийн дархад иргэдийн дунд явуулсан судалгаа⁵, “Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого-нэгдсэн дүн” зэрэг судалгааны материалуудыг ашиглан монгол орны нутгийн аялгуунуудаас⁶ дархад, хотон, казак, халх аялгуунуудыг сонгон дээрх 9 шалгуураар

⁴Я.Бадамсүрэн 2009

⁵Ц. Баасанхүү “Дархад аялгууны өнөөгийн айдлыг нийгмийн хэлшинжлэлийн үүднээс судлах нь”
Магистрын ажил, Уб., 2010

⁶Сил Интернэшнл SILInternational/The Summer Institute of Language/ олон улсын байгууллагаас эрхлэн гаргадаг Этнологи: Дэлхийн хэлнүүд /Ethnologue: Languages of the World /номын 17 дахь хэвлэл (2013)-д Манай монгол хэлний нутгийн аялгуунуудыг хэл гэж авч үзсэн байна.

ангилж үзсэнээ толилуулж байна. Эдгээр шалгуур тус бүр дотроо 1-5 хүргэлх оноогоор үнэлэгдэх асуултуудтай бөгөөд энэ бүхнийг хавсралтаар харуулав.

Хүчин зүйлс	Хэлнүүд			
	дархад	хотон	казак	халх
1. Тухайн хэлийг хойч үе нь өвлөж авсан эсэх	1	1	5	5
2. Тухайн хэлээр харилцагчдын тоо	21. 558	11. 304	101. 526	2. 168. 1
3. Нийт хүн амын дунд тухайн хэлээр харилцагчдын эзлэх хувь	0. 8%	0. 4%	3. 9%	82. 4%
4. Тухайн хэлээр харилцагчдын шилжилт хөдөлгөөн	1	1	5	5
5. Тухайн хэл хүрээгээ тэлж байгаа эсэх болон хэвлэл мэдээллийн салбарт хэрэглэгдэж байгаа эсэх	0	0	4	5
6. Хэлний боловсрол болоод утга зохиолын салбарт тухайн хэл дээр бэлэн материал байгаа эсэх	0	1	5	5
7. Засгийн газрын болоод олон улсын хандлага, бодлого /албан ёсны статустай юу? Хэрэглээ нь ямар байна гэх мэт/	0	0	4-5	5
8. Тухайн хэлээр харилцагч нийгмийн бүлэглэлийн өөрийн эх хэлэндээ хандах хандлага	0	0	5	5
9. Тухайн хэлний баримтжуулалтын төрөл, тоо хэмжээ, түвшин	0	1	5	5

Эндээс дүгнэж үзэхэд дээрх 4 аялгуут хэл гэж үзээд өмнөх 9 ангиллаар авч үзэхэд халх болон казак аялгуу нь мөхлийн аюулгүй хэлэнд/safe/, харин хотон болон дархад аялгуу нь бараг мөхсөн хэл /Critically endangered/ гэсэн ангилалд орж байна. Энд тэмдэглэн хэлэхэд бид нутгийн аялгуут хэл гэж үздэггүй байхад олон улсын байгууллага манай нутгийн аялгуут хэл гэсэн ангилалд оруулаад зарим нэгийг нь мөхөж байгаа хэл гэж үзсэн нь анхаарал татаж байна. /хавсралт үзнэ үү. /

НОМЗҮЙ

1. Даяаршил хийгээд монгол хэл бичгийн асуудалд, эмхэтгэсэн О. Адъяа. МУ-ын ШУА, НУ-ы салбарын бага чуулган. УБ. , 2002
2. Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудлууд /Хэлсэн үгийн эмхэтгэл/ Эмхэтгэсэн Б. Ширнэн. УБ. , 2005

Англи ном:

1. Bernard Spolsky. Language policy (Key topics of sociolinguistics). Cambridge University Press. , 2003
2. Center for applied linguistics. [Http://www. cal. org/yol/statement. html](http://www.cal.org/yol/statement.html)
3. Directions in sociolinguistics. Ed. bu J. J. Gumperz, D. ymes. New York. 1972.
4. James Crawford. Sociolinguistic theory: Linguistic Variation and it's social significance (language in societies). 2003
5. Sociolinguistics. Ed. bu. N. Coupland. A. Jamorski. London. 1997

6. Sue Wright "Language policy and language planning": From nationalism to Globalization. 2003

SUMMARY

In this article, the author introduces some of the activities undertaken by international organizations (Chinese and Australian) in making surveys on language vitality and endangerment of their indigenous languages and implementing several useful projects and carry out their own activities on language saving and language endangerment.

Хавсралт1.

1-р хүчин зүйл нь: Тухайн хэлийг хойч үе нь өвлөж авсан эсэх

Мөхлийн зэрэг	Үнэлгээ	Харилцагч хүн ам
Аюулгүй/Safe	5	Тухайн хэлээр хүүхэд багачуудаас эхлээд бүх насныхан харилцдаг
Эрсдэлтэй /Unsafe	4	Тухайн хэлээр хүүхдүүдийн ихэнх нь харилцдаг хэдий ч зарим газарт хязгаарлагдмал хэрэглэдэг
Мөхлийн аюулд байгаа /Definitely endangered	3	Тухайн хэлийг аав ээжийн үеийн болоод тэднээс дээш үеийн ихэнх хүмүүс мэддэг
Мөхлийн онцгой аюулд байгаа/Severely endangered	2	Тухайн хэлийг өвөө эмээгийн үеийн болоод тэднээс дээш үеийн ихэнх хүмүүс мэддэг
Бараг мөхсөн /Critically endangered	1	Тухайн хэлийг элэнц хуланцийн үеийн маш цөөн хүмүүс л мэддэг
Мөхсөн /Extinct	0	Тухайн хэлээр харилцагч үлдээгүй

2-р хүчин зүйл нь: Тухайн хэлээр харилцагчдын тоо

3-р хүчин зүйл нь: Нийт хүн амын дунд тухайн хэлээр харилцагчдын эзлэх хувь

Мөхлийн зэрэг	Үнэлгээ	Нийт хүн амын дунд тухайн хэлээр харилцагчдын эзлэх хувь
Аюулгүй	5	Бүх иргэд тухайн хэлээр харилцдаг
Эрсдэлтэй	4	Бараг бүх иргэд тухайн хэлээр харилцдаг
Мөхлийн аюулд байгаа	3	Хүн амын ихэнх нь тухайн хэлээр харилцдаг
Мөхлийн онцгой аюулд байгаа	2	Хүн амын цөөнх нь тухайн хэлээр харилцдаг
Бараг мөхсөн	1	Маш цөөн хүн тухайн хэлээр харилцдаг
Мөхсөн	0	Тухайн хэлээр харилцагч үлдээгүй

--	--	--

4-р хүчин зүйл нь: Тухайн хэлээр харилцагчдын шилжилт хөдөлгөөн

Мөхлийн зэрэг	Үнэлгээ	Хэрэглэгчид болон үүрэг
Бүх нийтийн хэрэглээ	5	Тухайн хэлийг нийгмийн бүх харилцагчид бүх л үүргээр нь хэрэглэдэг.
Олон хэлний тэнцвэрт байдал	4	Хоёр буюу түүнээс олон хэл нийгмийн ихэнх харилцагчдын хүрээнд маш олон үүрэгтэй хэрэглэгдэж болох бөгөөд үе удам дамжин өвлөгдөж ирсэн хэл нь олон нийтийн харилцаанд хэрэглэгдэх нь ихэвчлэн ховор.
Хэрэглэгчид нь багасах	3	Үе дамжин өвлөгдөж ирсэн хэл нь гэр бүлийн хүрээнд олон үүргээр хэрэглэгддэг хэдий ч олонхийн хэл нь гэр бүлийн хүрээнд нэвтэрч эхэлсэн.
Хязгаарлагдмал эсвэл албан хүрээ	2	Тухайн хэл нийгмийн хязгаарлагдмал хүрээнд цөөн хэдэн үүргээр хэрэглэгддэг.
Маш хязгаарлагдмал	1	Тухайн хэл маш хязгаарлагдмал хүрээнд маш цөөн үүрэгтэй хэрэглэгддэг
Мөхсөн	0	Тухайн хэл ямар ч харилцагчгүй болсон.

5-р хүчин зүйл нь: Тухайн хэл хүрээгээ тэлж байгаа эсэх болон хэвлэл мэдээллийн салбарт хэрэглэдэг эсэх

Мөхлийн зэрэг	Үнэлгээ	Тухайн хэл хүрээгээ тэлж байгаа эсэх болон хэвлэл мэдээллийн салбарт хэрэглэдэг эсэх
Амьд хэл	5	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн бүхий л хүрээнд хэрэглэдэг.
Идэвхтэй хэл	4	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн ихэнх хүрээнд хэрэглэдэг.
Receptive	3	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн зарим хүрээнд хэрэглэдэг.
Copying	2	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн цөөн хүрээнд хэрэглэдэг.
Маш бага хэрэглэдэг	1	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн маш бага хүрээнд хэрэглэдэг.
Идэвхгүй	0	Тухайн хэлийг нийгмийн бүлэглэлийн ямарч хүрээнд хэрэглэдэггүй.

6-р хүчин зүйл нь: Хэлний боловсрол болоод утга зохиолын салбарт тухайн хэл дээр бэлэн хэрэглэгдэхүүн байгаа эсэх

Үнэлгээ	Бичгийн материалын хүртээмж
5	Тогтсон зөв бичгийн дүрэмтэй, хүүрнэл зохиол, шинжлэх ухааны зохиол, өдөр тутмын мэдээ мэдээлэл зэрэг утга зохиолын уламжлалтай, бөгөөд тухайн хэлийг засаг захиргааны болон боловсролын түвшинд хэрэглэдэг.
4	Бичгийн материал байдаг ба хүүхдүүд сургууль дээрээ тухайн хэлний утга зохиолыг ашигладаг. Хэл нь засаг захиргааны түвшинд бичгийн хэлбэрээр хэрэглэгддэггүй.

3	Бичгийн материал байдаг ба хүүхдүүд сургууль дээрээ тухайн хэлний бичгийн хэлбэрийг ашигладаг дүр эсгэдэг төдийгүй утга зохиолын болоод хэвлэмэл материал ашигладаггүй.
2	Бичгийн материал байгаа хэдий ч хүмүүсийн зарим нь л ашигладаг, зарим хүмүүсийн хувьд энэ нь бэлгэдлийн чанартай. Сургуулийн сургалтын хөтөлбөрт нь тухайн хэлээр утга зохиолын хичээл ордоггүй.
1	Олон нийтэд зориулсан хэрэглээний зөв бичгийн дүрэм байдаг гэдгийг мэддэг ба хааяа нэг бичгийн материал олддог.
0	Зөв бичих дүрмийн ямар ч материал байхгүй

7-р хүчин зүйл нь: Засгийн газрын болоод олон улсын хандлага, бодлого /албан ёсны статустай юу? Хэрэглээ нь ямар байна гэх мэт/

Дэмжлэгийн зэрэг	Үнэлгэ э	Хэлэндээ хандах албан ёсны хандлага
Адил тэнцүү дэмждэг	5	Бүх хэл хамгаалагдсан
Ялгаатай дэмждэг	4	Цөөнхийн хэлүүд нь ноёлогч хэлний нэгэн адил хамгаалагдсан, цөөнхийн хэлний хэрэглээ нь нэр хүндтэй
Хэлийг нь аажмаар уусгах	3	Цөөнхийн хэлийг хамгаалах талаар ямар ч тодорхой бодлого байхгүй, ноёлогч хэл голлох үүрэг гүйцэтгэдэг
Хэлийг нь идэвхийлэн уусгах	2	Цөөнхийн хэлийг ноёлогч хэлэнд уусгахыг засгийн газраас нь дэмждэг, цөөнхийн хэлийг хамгаалдаггүй
Хэлийг нь хүчээр уусгах	1	Бусад цөөнхийн хэлнүүдийг хамгаалдаггүй бас хүлээн зөвшөөрдөггүй хирнээ ноёлогч хэлийг цорын ганц албан ёсны хэл болгосон
Хориглох	0	Цөөнхийн хэлийг хэрэглэхийг хориглосон

8-р хүчин зүйл нь: Тухайн хэлээр харилцагч нийгмийн бүлэглэлийн эх хэлэндээ хандах хандлага

Үнэлгээ	Тухайн хэлээр харилцагч нийгмийн бүлэглэлийн эх хэлэндээ хандах хандлага
5	Бүх хүмүүс эх хэлээ өндрөөр үнэлж хамгаалахыг хүсдэг
4	Хүмүүсийн ихэнх нь хэлний хөгжлийг дэмждэг
3	Хүмүүсийн зарим нь хэлний хөгжлийг дэмждэг, зарим нь хэлний шилжилт хөдөлгөөнийг дэмжих хандлагатай
2	Хүмүүсийн зарим нь хэлний хөгжлийг дэмждэг, зарим нь дэмждэггүй төдийгүй хэлний шилжилт хөдөлгөөнийг дэмждэг
1	Цөөн хэдэн хүн л хэлний хөгжлийг дэмждэг, хүмүүсийн ихэнх нь хэлний шилжилт хөдөлгөөнийг дэмждэг
0	Хэлээ хамгаалах талаар хэн ч анхаарал хандуулдаггүй, бүгд ноёлогч хэлний хэрэглээг илүүд үздэг

9 хүчин зүйл нь: Тухайн хэлийг баримтжуулсан төрөл, тоо хэмжээ, түвшин

Баримтжуулалтын чанар	Үнэлгээ	Хэлний баримтжуулалт
Маш сайн	5	Дэлгэрэнгүй дүрэм, толь бичиг, хангалттай хэмжээний бичвэрүүд зэрэгхэлний материал байнга эргэлддэг байх төдийгүй арвин баялаг тайлбар тэмдэглэгээ бүхий дээд зэргийн чанартай аудио болон видео бичлэгтэй байх
Сайн	4	Наад зах нь нэг сайн дүрэмтэй, хэд хэдэн толь бичиг болоод бичвэрүүдтэй, утга зохиолын бүтээл болоод өдөр тутмын мэдээ мэдээлэлтэй, хангалттай тайлбар тэмдэглэгээ бүхий дээд зэргийн чанартай аудио болон видео бичлэгтэй байх
Дунд зэрэг	3	Боломжийн хэмжээний хэрэглээний дүрэм, толь бичиг, бичвэрүүдтэй хэдий ч өдөр тутмын мэдээ мэдээлэл байхгүй, дуу болон дүрс бичлэг байж болох ч чанар болоод тайлбар тэмдэглэгээний хувьд харилцан адилгүй.
Хэсэг хэсгийг баримтжуулсан	2	Дүрмийн хувьд зарим нэг хэрэглэгдэхүүний, хязгаарлагдмал хүрээнд хэл шинжлэлийн судалгаа хийхэд ашиглах үгийн жагсаалт болон бичвэртэй хэдий ч хамрах хүрээ нь хангалтгүй. Дуу болон дүрс бичлэг байж болох ч чанарын хувьд харилцан адилгүй, ба зарим нь бага сага тайлбар тэмдэглэгээтэй, зарим нь ямар ч тайлбар тэмдэглэгээ байхгүй.
Маш хангалтгүй	1	Дүрмийн хувьд маш хангалтгүй хэрэглэгдэхүүнтэй, үгийн жагсаалт нь маш бага бөгөөд хэсэг бусад, ашиглах боломжгүй бичвэрүүдтэй, дуу болон дүрс бичлэг байхгүй, байсан ч ашиглах боломжгүй, ямар ч тайлбар тэмдэглэгээ байхгүй.
Огт баримтжуулаагүй	0	Ямар ч баримт сэлт байхгүй.